

ХУУЛИЙН ЭТГЭЭД СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЗАРЛАЛ

2020.11.20

1. Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газар нь **“Төсвийн байгууллага, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн жилийн эцсийн санхүүгийн тайланд гэрээгээр аудит хийх”** хараат бус аудитын компанийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулахаар төлөвлөж байгаа тул оролцох хүсэлтэй хуулийн этгээдийг мэдээллээ ирүүлэхийг урьж байна.
2. Энэхүү аудитын хуулийн этгээд нь улс, орон нутгийн төсвийн байгууллага, орон нутгийн өмчит болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээд нийлсэн БагцI -26, БагцII -27, БагцIII -26 байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Төсвийн тухай хуулийн цагалбарт заасан хугацаанд аудитыг хийж гүйцэтгэнэ.
3. Мэдүүлгээ ирүүлж буй аудитын хуулийн этгээд нь уг үйлчилгээг гүйцэтгэх чадвартайг нотлох дараах мэдээлэл болон холбогдох бичиг баримтын баталгаат хуулбарыг Өмнөговь аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлнэ. Үүнд:
 1. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар
 2. Тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбар
 3. Татварын тодорхойлолт /цахим/
 4. Нийгмийн даатгалын тодорхойлолт /цахим/
 5. ШШГЕГ-т хугацаа хэтэрсэн өр төлбөргүй талаарх тодорхойлолт
 6. Шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт
 7. ММНБИ-ийн тодорхойлолт
 8. Гүйцэтгэсэн адил төсөөтэй зөвлөх үйлчилгээний мэдээлэл /сүүлийн 3 жилээр/
 9. Үндсэн ажилтны анкет, боловсрол, мэргэшлийн гэрчилгээний хуулбар
 10. Үндсэн ажилтны нийгмийн даатгалын цахим лавлагаа /сүүлийн 1 жилээр/
 11. Санхүүгийн тайлан /сүүлийн 2 жилээр/
4. Сонирхсон хуулийн этгээд нэмэлт мэдээллийг 2020 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийн 17 цагийн өмнө авч болох бөгөөд материалаа дор дурдсан хаягаар 2020 оны 11 дүгээр сарын 24-ний дотор цахим хэлбэрээр ирүүлнэ үү.

Цахимаар хүлээн авах хаяг: Umnugovi@audit.gov.mn
Холбоо барих утас: 89008029

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР